

АУДИТЫН КОД: САГ-2018/15/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл

Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо

Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа

Утас:261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Аудитор С.Отгонхорлоо

Утас:261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	5
3	АУДИТЫН ТАЙЛАН	7
3.1	Оршил	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
3.5	Дотоод хяналт.....	10
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
3.7	Шилэн дансны мэдээлэл	10
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	11
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	11
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	12
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	13
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	13
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3.16	Үр өгөөжийн тооцоолол	14
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	15
4.1	Үндсэн хөрөнгийн талаар	16
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	17
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	17
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1026

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.201\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2018\0425SAG15.Docx

070422

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д. ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG15.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Ерөнхий сайд У.Хүрэлсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд “Үндэсний Дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид УТҮГ гэх/ нь урсгал үйл ажиллагааны зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 12-оос 2018 оны 4 дүгээр сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор




Ерөнхий сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн ХЭГ/670 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- I. Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтийн талаар
 - Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаар цаг үеэ олсон шуурхай лавлагаа, зөвлөмж боловсруулж, Ерөнхий сайдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллах;
 - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн болон улсын хөрөнгө оруулалтын статистик мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх;
 - Хөрөнгө оруулалтын бизнес форум зохион байгуулах;
- II. Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагааны талаар
 - Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах;
 - Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах;
 - Хэвлэмэл бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх;
 - Хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх;
- III. Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц хөтөлбөрийн талаар
 - Иргэдэд үйлчлэх төвийн ухаалаг систем нийлүүлэх /төрийн үйлчилгээний цахим машин/;
 - Тоон гарын үсэг нэвтрүүлэх;
 - Телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх сум, суурин газрын тоог нэмэгдүүлэх;
 - Тоон телевизийн нэвтрүүлгийн дамжуулалтын чанарыг сайжруулах;
 - Радио нэвтрүүлгийн дамжуулалтын чанарыг сайжруулах;
 - Интернетийн үйлчилгээ хүргэх сумдын тоог нэмэгдүүлэх;
 - Шинээр үүрэн холбооны үйлчилгээ хүргэх сум, багийн тоог нэмэгдүүлэх;
 - Харилцаа холбооны чиглэлээр хийгдэх судалгаа, сурталчилгааны тоог нэмэгдүүлэх;
 - Олон улсын чанартай авто зам дагуу үүрэн холбооны дэд бүтэц байгуулах цэгийн тоог нэмэгдүүлэх;
 - Шуудангийн хүргэлт, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах;
 - Төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулах;
 - Төрийн үйлчилгээний цахим машинаар иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх;
- IV. Ангилагдаагүй бусад хөтөлбөрийн талаар
 - 2017 онд Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 10 дахь удаагийн буюу 2016 оны нэгтгэл тайлан гаргах;
 - Дозиметрийн тохируулга, баталгаажуулалт хийх;
 - Цацрагийн хэмжилт, шинжилгээ явуулах;
- V. Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх талаар
 - Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу хугацаанд нь зохион байгуулах;
 - Иргэн, аж ахуйн нэгжид цахим худалдан авах ажиллагааны талаар цахим болон танхимын сургалт явуулах;
 - Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтын тоог нэмэгдүүлэх;
 - Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг тогтмол хийх;
 - Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт /өмч эзэмшлийн гэрээний дүгнэлтийн хувь/-ыг сайжруулах;



- Төрийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулж, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх;
- Өмч хувьчлалын үйл ажиллагааг цаг тухайд нь зохион байгуулж, орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх бодлого зэрэг болно.

Монгол Улсын Ерөнхий сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Ерөнхий сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 5 чиглэлээр 29 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Засгийн газрын хэрэг эрхлэх газар /цаашид ЗГХЭГ гэх/-ын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ЗГХЭГ-аас 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсвийн байгууллагууд, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /цаашид ТӨААТҮГ гэх/-ууд өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус тус мөрдөж байгаа тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

ЗГХЭГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тус газар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалтыг эрхлэн зохион байгуулах, дүгнэлт, зөвлөмж өгөх, бүх талын дэмжлэгээр хангах зорилгын дор тайлант онд 2 зорилт дэвшүүлэн “Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө” гарган ажиллажээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Ерөнхий сайдын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 5 чиглэлээр хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээг 31,718.6 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 37,051.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт 274,739.9 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр урсгал зардалд 85,252.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 186,671.6 сая төгрөг тус тус зарцуулж, батлагдсан төсвийг нийт 98.9 хувь буюу 2,815.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар хэтэрсэн зардал байхгүй байна.


Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргасан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Ерөнхий сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт;



2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт,
4. Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл;
5. Санхүүгийн тайлан;
6. Байгууллагын батлагдсан төсөв зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

1. УТҮГ, ТӨААТҮГ, Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, Засгийн газрын тусгай сангийн алдаа, зөрчлөөс дурьдвал:
 - “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК нь дараа тайлангаар олгох мөнгөний дээд хэмжээг хэтрүүлсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй худалдан авалт хийсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй,
 - “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь түрээсийн орлогын 30 хувийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, жишиг үнийг баримтлаагүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй,
 - “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь тайлант онд авлагын хэмжээ өссөн,
 - “Үндэсний Дата төв” УТҮГ нь авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй 40.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
 - Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна...”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Дээрх байгууллагуудын холбогдох албан тушаалтанд 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1,003.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулах, давтан гаргахгүй байх талаар 17 зөвлөмж өгөх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй худалдан авалт хийсэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэх.

2. Төсөвт байгууллагуудын алдаа, зөрчлөөс дурьдвал:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг 8 ТӨААТГ-ууд маргаантай байгаагаас дутуу төвлөрүүлсэн, түрээсийн орлого бүрэн тооцож төвлөрүүлээгүй,
- Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газар дуусаагүй үйлдвэрлэл дансанд олон жил хуримтлагдсан үлдэгдлийг холбогдох байгууллагууд руу шилжүүлэх асуудлыг шуурхай шийдвэрлэх,
- Мэдээллийн Монцамэ агентлаг түрээсийн төлбөрийн орлогыг нийт дүнгээр хоол, унааны зардлаар бүртгэсэн, бэлэн мөнгөөр хийгдсэн ажил гүйлгээг кассын дэвтэрт тухай бүр бүрэн хөтлөөгүй,
- Харилцаа холбооны зохицуулах хороо тусгай зөвшөөрлийн гэрчилгээг бичиг хэргийн зардлаар бүртгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.1-д "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна...", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т "Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдтэй холбоотой холбогдох албан тушаалтанд 107.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 3,439.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулах, давтан гаргахгүй байх талаар 9 зөвлөмж өгсөн.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Урсгал үйл ажиллагааны зардлын талаар:


Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага "Үндэсний Дата төв" УТҮГ нь тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал /Мэдээллийн технологийн үйлчилгээний зардал/-аас 789.5 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 21.1 сая төгрөгийн програм хангамж, нийт 810.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас төрийн болон ТӨААТҮГ-дад "Төрийн болон Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна...", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 402 дугаар тогтоолын 2-т "Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.



хэлтсийн даргын зөвшөөрөл бүхий албан бичгээр шийдвэрлэж байгаа тул холбогдох байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд улсын төсөвт орлогыг бүрдүүлж буй өмч хувьчлалын орлого, ногдол ашиг төвлөрүүлэлтэд нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Үндэсний хөгжлийн газрын Барилга байгууламж дансанд бүртгэлтэй 400.0 сая төгрөгийн өртөгтэй цэвэр усны эх үүсвэрийн шугам, 22,543.9 сая төгрөгийн өртөгтэй 9 сургууль, цэцэрлэгийн барилга, Зам гүүрийн барилга байгууламж дансанд бүртгэлтэй 13,141.7 сая төгрөгийн өртөгтэй 15.8 км хатуу хучилттай зам зэрэг, нийт 36,085.6 сая төгрөгийн өртөгтэй өмнөх онуудад болон тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар буюу концессын гэрээгээр хийгдсэн хөрөнгүүдийг улсын комисс хүлээн авсан боловч харьяалагдах байгууллагууд руу шилжүүлээгүй байгааг анхаарч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шилжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 13,079.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан 4 байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 810.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн ба зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлжээ.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 9 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 12,269.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, аудитын явцад 7,691.9 сая төгрөгийг алдааг залруулж, 107.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах төлбөрийн акт тогтоож, 26.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 4,442.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулах, давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 26 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг 2017 оны жилийн эцсийн байдлаар 72 хувьтай биелүүлсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.


3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн дүнг сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг батлагдсан төсвийн дүн 274.739.9 сая төгрөгийн 1 хувь буюу 2,747.4 сая төгрөгөөр тооцон материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажуулав.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг багалаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 918.2 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЗГХЭГ-ын Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага “Үндэсний Дата төв” УТҮГ нь тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал /Мэдээллийн технологийн үйлчилгээний зардал/-аас 789.5 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 21.1 сая төгрөгийн програм хангамж, нийт 810.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Урсгал үйл ажиллагааны зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хууль, эрхзүйн актууд зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	142,560,555.4	159,866,918.5
Мөнгөн хөрөнгө	24,287,956.2	37,614,480.4
Авлага	15,721,292.1	25,840,572.0
Урьдчилгаа	7,282,904.8	8,071,370.0
Бараа материал	95,260,828.9	88,336,130.8
Бусад эргэлтийн хөрөнгө	7,573.5	4,365.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	260,736,738.9	437,991,679.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	260,736,738.9	437,991,679.8
Биет хөрөнгө	253,798,070.6	423,592,322.0
Биет бус хөрөнгө	6,938,668.3	9,139,676.5
Бусад хөрөнгө	-	5,259,681.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	403,297,294.3	597,858,598.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	75,904,960.3	66,585,557.2
Богино хугацаат өр төлбөр	8,468,466.4	16,500,381.1
Урт хугацаат өр төлбөр	67,436,493.9	50,085,176.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	327,392,334.1	531,273,041.1
Засгийн газрын хувь оролцоо	327,392,334.1	531,273,041.1
Засгийн газрын оруулсан капитал	186,836,410.0	203,564,518.8
Хуримтлагдсан үр дүн	131,668,227.8	320,015,580.0
Өмнөх үеийн үр дүн	10,215,256.8	128,295,431.3
Тайлант үеийн үр дүн	121,452,971.0	191,720,148.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,887,696.3	7,692,942.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	403,297,294.3	597,858,598.3

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	275,507,765.0	377,210,228.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	106,652,455.5	107,746,107.0
Нийтлэг татварын бус орлого	106,023,293.0	90,656,451.2
Хөрөнгийн орлого	253,802.3	17,079,820.6
Тусламжийн орлого	375,360.3	9,835.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,855,309.5	269,464,121.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	146,606,542.3	178,216,611.4
УРСГАЛ ЗАРДАЛ	140,813,811.2	174,006,580.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,554,487.5	139,134,975.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,067,616.1	57,547,742.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,860,076.8	3,381,225.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,417,414.4	4,660,983.5
Хангамж, бараа материалын зардал	2,945,698.7	4,689,609.6
Нормативт зардал	680,950.6	8,372.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,126,706.5	1,194,909.5
Томилолт, зочны зардал	790,699.3	928,021.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,303,256.4	10,091,930.8
Бараа үйлчилгээний бусад зардал	53,362,068.8	56,632,179.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,259,323.6	34,871,605.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,088,102.2	1,365,615.8
Бусад урсгал шилжүүлэг	1,151,666.3	519,260.2
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	887,031.1	30,951,887.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,132,524.1	2,034,842.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,792,731.1	4,210,030.7
Дотоод эх үүсвэрээр	5,792,731.1	4,210,030.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	128,901,222.7	198,993,617.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	885,659.9	(1,009,544.9)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,333,911.5	6,263,923.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(7,448,251.6)	(7,273,468.8)
НИЙТ ҮР ДҮН	121,452,971.1	191,720,148.7



5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧ
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,016,120.1		192,016,120.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,231,410.3		20,231,410.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,247,530.4		212,247,530.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(98,968.8)		(98,968.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(6,261,559.9)		(6,261,559.9)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	52,361.4		52,361.4
Тайлант үеийн үр дүн	121,452,971.0		121,452,971.0
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,392,334.1		327,392,334.1
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	327,392,334.1		327,392,334.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,616,405.3)		(2,616,405.3)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,775,928.9		324,775,928.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,194,754.0)		(1,194,754.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	16,728,108.8		16,728,108.8
Зарласан ногдол ашиг	(756,391.3)		(756,391.3)
Тайлант үеийн үр дүн	191,720,148.7		191,720,148.7
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,273,041.1		531,273,041.1




5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	260,966,893.2	383,884,643.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	92,012,865.6	114,425,718.3
Нийтлэг татварын бус орлого	92,012,865.6	114,425,718.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,954,027.6	269,458,924.9
Улсын төвлөрсөн төсвөөс	85,273,987.9	90,250,417.6
Хөрөнгийн санхүүжилт	77,772,129.1	178,736,218.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,898,768.3	463,641.1
Төвлөрүүлэх шилжүүлэг		-
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,142.3	8,647.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	124,082,644.2	161,304,204.1
УРСГАЛ ЗАРДАЛ	124,082,644.2	161,304,204.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,627,063.1	106,359,603.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,406,528.9	57,216,413.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,370,528.7	4,820,724.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,758,598.2	9,296,962.7
Хангамж, бараа материалын зардал	3,097,318.4	3,059,168.8
Нормативт зардал	701,532.1	10,450.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,378,223.6	616,346.4
Томилолт, зочны зардал	472,350.0	486,020.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,019,669.8	9,969,040.3
Бараа үйлчилгээний бусад зардал	24,422,313.5	20,884,476.7
ТАТААС	3,749,448.7	3,643,017.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,706,132.4	51,301,582.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,086,702.2	1,365,615.8
Бусад урсгал шилжүүлэг	1,301,799.2	538,206.1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	892,523.9	16,652,527.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,109,142.5	32,316,762.5
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	315,964.5	428,471.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	136,884,249.0	222,580,439.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,174.1	74,012.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	121,921,099.7	206,447,584.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	121,921,099.7	206,447,584.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(121,912,925.7)	(206,373,572.1)
Бусад эх үүсвэр	336,069.9	22,581.9
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	771,479.5	2,902,924.5
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(435,409.6)	(2,880,342.6)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	14,535,913.7	13,326,524.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,752,042.5	24,287,956.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,287,956.2	31,614,480.4



Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	ХУВЬ
	БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	274,739,921.4	271,924,034.2	2,815,887.2	98.98
УРСГАЛ ЗАРДАЛ	85,889,158.0	85,252,377.2	636,780.8	99.26
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,586,769.0	77,103,876.1	482,892.9	99.38
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,007,646.5	41,864,527.3	143,119.2	99.66
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,484,182.1	1,460,976.1	23,206.0	98.44
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	651,956.4	570,467.1	81,489.3	87.5
Хангамж, бараа материалын зардал	468,308.0	452,486.3	15,821.7	96.72
Нормативт зардал	220.1	208.2	11.9	94.58
Эд хогшил, урсгал засварын зардал	357,451.0	356,073.3	1,377.7	99.61
Томилолт, зочны зардал	150,849.9	139,601.6	11,248.3	92.54
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,471,069.9	2,423,106.2	47,963.7	98.07
Бараа үйлчилгээний бусад зардал	29,995,085.1	29,836,429.9	158,655.2	99.47
ТАТААС	6,713,102.0	6,574,119.6	138,982.4	97.93
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,589,287.0	1,574,381.6	14,905.4	99.06
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,348,563.9	1,345,755.4	2,808.5	99.79
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,348,563.9	1,345,755.4	2,808.5	99.79
Бусад урсгал шилжүүлэг	240,723.1	228,626.2	12,096.9	94.97
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	188,850,763.4	186,671,657.0	2,179,106.4	98.85
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	274,739,921.4	272,007,887.7	2,732,033.7	98.98
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	271,317,428.0	268,564,202.9	2,753,225.1	98.99
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,422,493.4	3,443,684.8	-21,191.4	98.42
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,427.1		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	9,982.8		

